

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/174/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА Б.БААСАНСҮРЭН
ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.11 № 01/62
танай _____-ны № _____-т

**Хараат бус аудиторын дүгнэлт
Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Ханх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Ханх сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй нь аудиторыг хангалттай нотлох баримтаар хангаагүй.
2. Тайлант онд хөрөнгийн тооллого хийгээгүй,
3. Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 20,750.6 сая төгрөгийг цалингийн зардалд эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан,
4. Буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх 27,700.7 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.
5. Малжуулах хөтөлбөрийн хүрээнд 2021 онд үүссэн 21,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, малчидтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болсон байхад гэрээг дүгнэж, хэрэгжилтийг тооцоогүй байна.

Дээрх зөрчлүүд нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1 дэх хэсэгт "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь хэсэгт "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна."; Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын

67-8078339

зөрчсөн, Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөөгүй, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг, Оршин байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Дээрх зөрчлийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 49,861.2 мянган төгрөгөөр давсан байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бараа материал данс өмнөх оноос 108,718.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2025 оны А/04-А/95 дугаар тушаалуудаар 90,339.0 мянган төгрөгийн "өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарт ашиглалтын гэрээгээр ашиглуулах" хөрөнгүүдийг шилжүүлсэнтэй холбоотой өсөлт байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 808,125.0 мянган төгрөгийн 8 зөрчил илэрч, 73,523.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж, санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, шилэн данстай холбоотой 2 зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, хөрөнгийн тооллого хийгээгүй болон худалдан авах ажиллагаатай холбоотой 2 зөрчилд зөрчил таслан зогсоох 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант онд "Сум орон нутгийнхаа хөгжил цэцэглэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бодитой төлөвлөж иргэдийнхээ өрхийн орлогыг үе шаттайгаар нэмэгдүүлж, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, аюулгүй тайван орчинд амьдрах боломжийг бүрдүүлсэн жишиг сум болно." гэсэн зорилгын хүрээнд 6 зорилт 48 арга хэмжээ төлөвлөн 90 хувийн биелэлттэй дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	150,661,049.63	259,379,182.13
33	АВЛАГА	50,996,354.75	50,996,354.75
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	560,389.79
335	Бусад авлага	50,996,354.75	50,435,964.96
3352	Хувь хүмүүсээс авах авлага	50,996,354.75	50,435,964.96
35	БАРАА МАТЕРИАЛ	99,664,694.88	208,382,827.38
351	Түүхий эд материал	4,072,200.00	4,072,200.00
35110	Тусгай зориулалттай материал	4,072,200.00	4,072,200.00
354	Хангамжийн материал	77,364,494.88	186,082,627.38
35410	Бичиг хэргийн материал	799,100.00	1,268,600.00
35420	Аж ахуйн материал	49,124,844.00	110,318,639.00
35440	Түлш, шатах тослох материал	9,351,650.88	26,639,738.38
35450	Барилгын засварын материал	405,000.00	405,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,683,900.00	47,450,650.00
35600	Мал амьтад	18,228,000.00	18,228,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,999,823,508.85	3,157,036,698.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,999,823,508.85	3,157,036,698.34
392	Биет хөрөнгө	2,932,977,508.85	3,077,690,698.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,366,923,931.00	2,596,647,504.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-515,321,789.59	-618,290,654.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	892,900,518.00	1,086,700,518.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-137,583,308.38	-259,571,594.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	167,678,514.80	170,252,976.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,860,955.84	-87,611,808.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,679,401.00	67,679,401.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,333,924.52	-41,731,975.84
39209	Зам, гүүрийн байгууламж	114,000,000.00	114,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-31,138,888.54	-37,499,999.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	151,933,699.00	151,933,699.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-49,899,688.08	-64,817,367.00
393	Биет бус хөрөнгө	66,846,000.00	79,346,000.00
39301	Програм хангамж	00.00	2,930,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,930,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	66,846,000.00	79,346,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,150,484,558.48	3,416,415,880.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,150,484,558.48	3,416,415,880.47
51	Засгийн газрын хувь оролцоо	3,150,484,558.48	3,416,415,880.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	759,000,860.17	759,000,860.17
51101	Өмч: - төрийн	759,000,860.17	759,000,860.17
512	Хуримтлагдсан үр дүн	2,025,711,592.37	2,291,642,914.36
51210	Өмнөх үеийн үр дүн	2,025,711,592.37	2,025,711,592.37
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	265,931,321.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	365,772,105.94	365,772,105.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,150,484,558.48	3,416,415,880.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,680,959,362.75	1,623,393,907.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	624,046,000.00	532,621,079.93

120	Нийтлэг татварын бус орлого	624,046,000.00	532,621,079.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	624,046,000.00	532,621,079.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	596,116,000.00	426,098,034.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	27,930,000.00	103,593,045.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,056,913,362.75	1,090,772,827.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,695,162.75	9,327,327.79
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,765,734.00	9,327,327.79
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,929,428.75	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	964,218,200.00	1,081,445,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	964,218,200.00	1,081,445,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,224,383,936.93	1,354,532,585.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,224,383,936.93	1,354,532,585.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,169,317,321.46	1,315,741,974.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,792,285.78	771,853,070.72
210101	Үндсэн цалин	420,465,851.25	455,971,930.35
210102	Нэмэгдэл	228,785,634.53	301,520,340.37
210104	Урамшуулал	12,540,800.00	14,360,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,995,800.00	94,465,875.85
210201	Тэтгэврийн даатгал	53,910,726.35	63,607,655.38
210202	Тэтгэмжийн даатгал	6,670,517.07	7,732,780.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,208,349.40	3,866,390.05
210204	Ажилгүйдлийн даатгал	3,208,349.40	3,851,810.05
210205	Эрүүл мэндийн даатгал	13,997,857.78	15,407,240.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,141,650.00	47,634,811.84
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	12,599,999.34
210302	Түлш, халаалт	24,141,650.00	33,034,912.50
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	1,999,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,712,386.00	56,309,400.00
210401	Бичиг хэрэг	22,521,100.00	15,906,600.00
210402	Тээвэр, шатахуун	31,591,286.00	25,928,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,011,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,600,000.00	11,463,300.00
2105	Нормативт зардал	1,106,000.00	4,714,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,106,000.00	4,714,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,317,000.00	17,732,500.00
210604	Урсгал засвар	13,317,000.00	17,732,500.00
2107	Томилолт, зочны зардал	8,368,875.00	8,230,000.00
210702	Дотоод албан томилолт	8,368,875.00	8,230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,296,158.00	12,652,971.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,994,410.00	9,563,971.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,584,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	112,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,104.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,200.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,950,000.00	2,089,000.00
210807	Газрын төлбөр	448,444.00	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	249,587,166.68	302,149,345.44

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,057,950.00	17,564,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	3,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	211,929,216.68	281,384,845.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,066,615.47	38,790,610.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,715,340.00	18,541,072.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,655,340.00	14,329,872.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,060,000.00	4,211,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,351,275.47	20,249,538.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,351,275.47	20,249,538.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	456,575,425.82	268,861,321.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	456,575,425.82	268,861,321.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,040,265,934.00	1,090,772,827.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,039,665,934.00	1,090,772,827.79
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,447,734.00	9,327,327.79
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,765,734.00	9,327,327.79
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,682,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	964,218,200.00	1,081,445,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	964,218,200.00	1,081,445,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,011,837,934.00	1,090,772,827.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,011,837,934.00	1,090,772,827.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	956,771,318.53	1,051,982,216.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,814,899.53	751,102,446.57
210101	Үндсэн цалин	360,935,335.38	393,951,457.77
210102	Нэмэгдэл	289,879,564.15	344,444,889.66
210104	Урамшуулал	11,000,000.00	12,706,099.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,995,800.00	115,216,500.00
210201	Тэтгэврийн даатгал	55,957,000.00	84,983,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,259,700.00	7,558,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,129,900.00	3,779,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,129,900.00	3,779,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,519,300.00	15,116,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,000,000.00	64,599,899.34
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	12,599,999.34
210302	Түлш, халаалт	20,000,000.00	50,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	1,999,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,359,586.00	56,778,900.00

210401	Бичиг хэрэг	19,464,600.00	16,102,100.00
210402	Тээвэр, шатахуун	29,294,986.00	25,928,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	3,285,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,600,000.00	11,463,300.00
2105	Нормативт зардал	1,106,000.00	4,014,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,106,000.00	4,014,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	17,700,000.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	17,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,368,875.00	8,230,000.00
210702	Дотоод албан томилолт	8,368,875.00	8,230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,985,208.00	13,575,971.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,683,460.00	10,486,971.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,584,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	112,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,104.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,200.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,950,000.00	2,089,000.00
210807	Газрын төлбөр	448,444.00	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,140,950.00	20,764,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,540,950.00	17,564,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	3,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,066,615.47	38,790,610.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,715,340.00	18,541,072.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,655,340.00	14,329,872.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,060,000.00	4,211,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,351,275.47	20,249,538.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,351,275.47	20,249,538.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,428,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,428,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,428,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,428,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,428,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28,428,000.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,000,860.17	369,816,400.69	-155,219,019.78	973,598,241.08
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,832,619,543.92	-6,852,021.82
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,000,860.17	365,772,105.94	6,677,400,524.14	3,150,484,558.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	759,000,860.17	365,772,105.94	2,025,711,592.37	3,150,484,558.48
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	268,861,321.99	268,861,321.99
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	759,000,860.17	365,772,105.94	2,294,572,914.36	3,419,345,880.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,113,518,800.0	1,068,523,288.9	44,995,511.1	96.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,113,518,800.0	1,068,523,288.9	44,995,511.1	96.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,093,194,400.0	1,049,982,216.9	43,212,183.1	96.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,820,000.0	751,102,446.6	4,717,553.4	99.4
210101	Үндсэн цалин	397,012,000.0	393,951,457.8	3,060,542.2	99.2
210102	Нэмэгдэл	344,444,900.0	344,444,889.7	10.3	
210104	Урамшуулал	14,363,100.0	12,706,099.1	1,657,000.9	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,216,500.0	115,216,500.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	84,983,700.0	84,983,700.0	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,558,200.0	7,558,200.0	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,779,100.0	3,779,100.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,779,100.0	3,779,100.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,116,400.0	15,116,400.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,600,000.0	64,599,899.3	100.7	100.0
210301	Гэрэл, цахилгаан	12,600,000.0	12,599,999.3	0.7	100.0
210302	Түлш, халаалт	50,000,000.0	50,000,000.0	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.0	1,999,900.0	100.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	82,313,300.0	56,778,900.0	25,534,400.0	69.0
210401	Бичиг хэрэг	27,000,000.0	16,102,100.0	10,897,900.0	59.6
210402	Тээвэр, шатахуун	37,800,000.0	25,928,500.0	11,871,500.0	68.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,350,000.0	3,285,000.0	65,000.0	98.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,163,300.0	11,463,300.0	2,700,000.0	80.9
2105	Нормативт зардал	4,014,000.0	4,014,000.0	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,014,000.0	4,014,000.0	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,700,000.0	17,700,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	17,700,000.0	17,700,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	10,600,000.0	8,230,000.0	2,370,000.0	77.6
210702	Дотоод албан томилолт	10,600,000.0	8,230,000.0	2,370,000.0	77.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,468,700.0	13,575,971.0	6,892,729.0	66.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,943,500.0	10,486,971.0	4,456,529.0	70.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.0	-	1,152,000.0	(100.0)
210803	Даатгалын үйлчилгээ	165,000.0	-	165,000.0	-

210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.0	-	120,000.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,200.0	-	88,200.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.0	2,089,000.0	911,000.0	69.6
210807	Газрын төлбөр	1,000,000.0	1,000,000.0	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,461,900.0	18,764,500.0	3,697,400.0	83.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,281,900.0	17,564,500.0	717,400.0	96.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,180,000.0	1,200,000.0	2,980,000.0	28.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,324,400.0	18,541,072.0	1,783,328.0	91.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,324,400.0	18,541,072.0	1,783,328.0	91.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,524,400.0	14,329,872.0	194,528.0	(1.3)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,800,000.0	4,211,200.0	1,588,800.0	72.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,113,518,800.0	1,068,523,288.9	44,995,511.1	96.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,113,518,800.0	1,068,523,288.9	44,995,511.1	96.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,113,518,800.0	1,068,523,288.9	44,995,511.1	96.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.0	23.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	7.0	7.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.0	12.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.0	4.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,327,327.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,327,327.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,327,327.8
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	7,327,327.8
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,327,327.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,327,327.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,327,327.8
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 201,213.4 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс аудитын явцад тус 5 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн бүртгэлийг Орон нутгийн өмчийн газраас ирсэн хөрөнгө эзэмшүүлэх шийдвэрүүдтэй тулгалт хийхэд 2024 онд хүлээн авсан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

2,574.5 мянган төгрөгийн өртөг бүхий **зөөврийн компьютер**, 2022-2023 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 188,011.1 мянган төгрөгийн **сумын төвийн гэрэлтүүлэг**, нийт 190,585.6 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2 дахь хэсэгт "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"*" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө бүртгэхдээ 9,789.0 мянган төгрөгийн хөрөнгө илүү бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "*Аж ахуйн нээж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.*" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдэл, бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлээс 20.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. НБББББ-ийн 5.3 Бараа материал хэсэгт нийцээгүй, Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Тайлант онд төлөгдсөн 560.4 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах авлагыг бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "*Аж ахуйн нээж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.*" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Бараа материалын тайланд 258.4 мянган төгрөгийн шатахууны зардлын гүйлгээ бичихдээ гадаад албан томилолтын зардлыг сонгож буруу бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "*Аж ахуйн нээж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.*" гэж заасныг зөрчсөн, Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 808,125.0 мянган төгрөгийн 8 зөрчил илэрч, 73,523.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж, санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, шилэн данстай холбоотой 2 зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, хөрөнгийн тооллого хийгээгүй болон ОНХС-ийн худалдан авах ажиллагаатай холбоотой 2 зөрчилд зөрчил таслан зогсоох 1 албан шаардлагыг Хөвсгөл аймгийн Ханх сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлаас 49,861.2 мянган төгрөгөөр хэтэрсэн тул "**Сөрөг**" дүгнэлт хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

1. Санхүүгийн тайлангийн иж бүрдэл дутуу ирүүлсэн, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт "*Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:*", Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "*Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*"-ын хоёрдугаар хавсралтыг тус тус зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. **Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих** төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө шууд худалдан авах аргыг ашиглах зорилгоор төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд: 13-н овооны тохижилтын ажил - 19,800.0 төгрөгөөр 3 хувааж шууд гэрээ байгуулсан, Бургасны рашааны хашаа, тохижилтын ажлыг 2 хувааж шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор*

батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Ханх сумын ЗДТГ-ын 2025 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс тодорхойлсон эрсдэлийн хүрээнд түүвэрлэн шалгахад тайлант оны хагас жилээс хойших 653,873.7 мянган төгрөгийн мэдээллийг огт мэдээлээгүй байна Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:"* гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Тайлант онд хөрөнгийн тооллого хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1 дэх хэсэгт "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;"* гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаатай холбоотой:

Илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналтын нэгж нь тайлант онд төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан *"Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"*-ын 3.6 дахь хэсэгт *"Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ"* гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг сайжруулж, төлөвлөсөн ажлыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, байгууллагыг эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцож, зөрчлийг арилгаж ажиллах. Байгууллагын шилэн дансны хөтлөлтийг онцгой анхаарч дотоод хяналтыг хэрэгжүүлэх

2. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой:

Илрүүлэлт: Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 20,750.6 сая төгрөгийг цалингийн зардалд эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөөгүй, Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид батлагдсан төсвийн хүрээнд зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх

Илрүүлэлт: Бараа материалын тайланд 4,072.2 мянган төгрөгийн үнэтэй ковидын үед нөөцийн зориулалтаар бэлтгэсэн тусгай зориулалттай материалын үлдэгдэл байна. Уг бараа материалын ашиглах хугацаа дууссан бөгөөд хөрөнгийн тооллогоор ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"Үйл ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангах"* гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Агуулахад хадгалаатай байгаа эм, эмнэлгийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг томилж, хугацаа дууссан бүтээгдэхүүнийг олж тогтоон нэр төрөл,

үнэ, хэзээ хаанаас авсан зэрэг мэдээлэл бүхий жагсаалт үйлдэж, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар”-ын дагуу хугацаа дууссан тэмдэг тэмдэглэгээ хийж тусгаарлан, устгалыг журмын дагуу шийдвэрлэх

Илрүүлэлт: Буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх 27,700.7 мянган төгрөг, Малжуулах хөтөлбөрийн хүрээнд 2021 онд үүссэн 21,000.0 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь хэсэгт "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малжуулах хөтөлбөр болон буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас авах авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СТ, тод зөрүүтэй	1	20.0			1	20.0				
Тайлант онд төлөгдсөн авлага бүртгээгүй	1	560.4	1	560.4						
Зардлын ангилал буруу бүртгэсэн	1	258.4			1	258.4				
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө бүртгэлд тусгаагүй	1	190,585.6	1	190,585.6						
Хөрөнгө илүү бүртгэсэн	1	9,789.0			1	9,789.0				
Дүн	5	201,213.4	2	191,146.0	3	10,067.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотоод хяналт хангалтгүй	1	-					1	-
Тайлангийн иж бүрдэл дутуу	1	-			1	-		
Хугацаа дууссан БМ-д арга хэмжээ аваагүй	1	4,072.2					1	4,072.2

Эдийн засаг ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан	1	20,750.6					1	20,750.6
Авлага барагдуулаагүй	1	48,700.7					1	48,700.7
Хөрөнгийн тооллого хийгээгүй	1	-		1	-			
Дүн	6	73,523.5		2	-		4	73,523.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хагас жилээс хойш огт мэдээлээгүй	1	653,873.7			1	653,873.7		
Дүн	1	653,873.7			1	653,873.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төсөвт өртгийг хувааж ШХА хийсэн	1	80,727.8			1	80,727.8		
Дүн	1	80,727.8			1	80,727.8		
Нийт дүн	2	734,601.5			2	734,601.5		